

№ 21/ 2024 оны 4 дүгээр сар

Амжилтанд хүрэхэд тууштай байх хэрэгтэй



Евразийн шилүүс ГИДЦГ-ын "Б" хэсэгт. 12-р сараас хойш тал газраараа 60 см хүртэл зузаан цасанд дарагдлаа. Дээр нь 3-р сард -38 хэм хүрч цасаар шуурав. Гэвч энэ удаад тахь өвлийг сайн давсан нь нэг талаар бид өнгөрсөн зуднаас сургамж авч зөв дүгнэлт хийснийх болов уу.

Зургийг: Н.Алтансүх

Зэрлэг адууны хүндэт анд найзуудаа



Байгаль хамгаалагч биднийг түгшээдэг зүйл бол томоохон байгалийн гамшиг нь маш их хүч чармайлт гарган сэргээн нутагшуулж буй тахийн популяцийг эмзэг болгох магадлалтай. Өнгөрсөн өвөл 18,000 км² газар нутагтай ГИДЦГ-ын Б хэсэгт зуд болж тахийн сүрэгт маш хүндээр туссан ба 2023/2024 оны өвөл их

цастай байлаа.

Гэхдээ бид өмнөх жилийн зуднаас зөв сургамж авч, ДЦГ-ын хамгаалалтын захиргаа өвс тэжээл худалдан авч нөөцөлснөөр энэ өвлийг тахь хүндрэл багатай давлаа. Энэ арга хэмжээ хүйтэн өвөл, цасан шуурганаар жийп машин хүртэл явах боломжгүй байх үед их тус болсон. Мөн хандивлагч таны ачаар бартаат замын цэргийн зориулалттай ачааны автомашиныг саяхан (баруун талын зураг) худалдаж авсан нь ирээдүйд тус дэм болно.

Өвс тэжээлийн нөөц сайн байсан тул өвөлдөө хангалттай тэжээл өгснөөр хохирол бараг амссангүй. Одоогийн байдлаар гурван тахь л үхсэн байна. Хоёрдугаар сарын сүүлчээр тахийн тоо толгой 260 орчим тоологдсоноос 252 нь батлагдсан.

Байгальд аль хэдийн устаж үгүй болсон эртний зэрлэг адууг устах аюулаас аварч, сүүлчийн хоргодож байсан газар нь нутагшуулж чадсан явдал бол төрөл зүйл хамгааллын хувьд үнэхээр гайхалтай амжилт юм. Гэвч чухам хэзээ үнэхээр амжилтанд хүрсэн гэж үзэх вэ? Хэзээ энэхүү устах аюулд ороод байсан зүйл дахин устах аюулгүй болох уу? Зөвхөн зэрлэг амьтны устаж алга болсон хугацаанаас илүү урт хугацаанд оршин тогтнох



магадлал өндөр байх үед л жинхэнэ амжилт гэх байх.

Ялангуяа амьтны хүрээлэнд л үлдэж, зэрлэг байгальдаа амьдрах, амьд үлдэх чухал мэдлэгээ алдсан зүйлийн хувьд маш урт хугацаа шаардах юм. Зудтай өвөл, малын хэт их өсөлтөөс үүссэн бэлчээрийн доройтлоос болж даамжирсан ган гачиг, малын халдварт өвчин, тэр бүү хэл гэрийн адуутай нийлж эрлийзжих зэрэг олон хүчин зүйл энэхүү зүтгэж олсон амжилтыг эрсдэлд оруулах магадлалтай.

Гэхдээ хашир, тууштай байж чадвал амжилтанд хүрэх боломжтой. Та бүхний тусламжтайгаар бид 2023 онд маш их амжилтад хүрсэн бөгөөд 2024 онд улам бататгах болно. Эцсийн эцэст, манай гараг дээрх хамгийн сүүлчийн жинхэнэ зэрлэг адууны олон сая жилийн хувьслын дараахь ирээдүй хэрхэх вэ гэдэг хамгийн том эрсдэл билээ.

Миний хувьд энэ асуудал маш чухал. Танд ч хамаатай болов уу?

ОУТГ-ийн Ерөнхийлөгч, доктор Рейнхард Шнидриг

Зөвхөн таны дэмжлэгээр энэхүү амжилтанд хүрсэн

Тодорхой зүйл амьтныг хамгаална гэдэг хүрээлэнгээр зугаалах явдал биш юм. Үүнд мөнгө санхүү, машин техник, эсвэл боловсон хүчний хомсдол нөлөөлж байдаг. Мөн экосистем болон ховор амьтдыг хамгаалах боломжгүй гэсэн үзэл бодолтой эрх баригчид, зарим хүмүүс, алсдаа тэднийг хадгалж үлдэх нь арилжааны зориулалтаар ашиглахаас илүү үнэ цэнэтэй гэдгийг ойлгодоггүй. Үүн дээр байгалийн эрсдэл, тухайлбал орон нутгийн уур амьсгал эсвэл халдварт өвчин нэмэгдэнэ.

Тууштай хүчин чармайлтгүйгээр ямар ч амжилтанд хүрэхгүй. Үүнд байгаль хамгаалагчид, эрх баригчид болон манай хөтөлбөрт багагүй цагаа зарцуулдаг сайн дурын ажилтнууд чухал үүрэгтэй. Манай үнэнч хандивын сан, хандивлагчидгүйгээр юу ч бүтэхгүй. 2022/2023 оны зудтай өвөл өвс тэжээлийг цаг хугацаанд нь худалдан авах боломж олгосон таны хандивыг бид талархан санадаг.

Мөн та бүхний хандив, Зүүнгарын говийн тахь, өвөрмөц экосистемийг хамгаалах хөтөлбөрийг үргэлжлүүлж, үе шаттайгаар сайжруулах боломжийг бидэнд олгосоор байна. Тахийн мэдээ сонины энэ дугаартаа бид Монгол улсын эрх барих байгууллагын төлөөлөгчдийн хамтаар жил бүрийн 1-р сарын сүүлчээр зохион байгуулдаг ОУТГ-ын семинарын үеэр хэлэлцсэн гол сэдвүүдийн талаар толилуулж байна.

“Манай гараг дээрх хамгийн сүүлчийн жинхэнэ зэрлэг адуу олон сая жилийн хувьслын дараа ирээдүйд эсэн мэнд орших эсэх нь гол асуудал билээ.”

Монголын говь: удахгүй Дэлхийн өвд бүртгэгдэх үү?

Төв Ази бол өвөлдөө хүйтэн, тал хээр буюу хагас цөлийн дэлхийн хамгийн чухал экосистем, биомын өлгий нутаг юм. Иймд Монгол Улс болон олон улсын 4 түнш байгууллага (үүнд ОУТГ) "Монголын говь"-ийг Дэлхийн өвд бүртгүүлэх санал дэвшүүлж байна. Үүнд БНХАУ-тай хиллэдэг 4 дархан цаазат газар, (Их говь А, Б, бага говь А, Б) мөн байгалийн хоёр дурсгалт газар орно. Эдгээр нь зэрлэг тэмээний дэлхийн сүүлчийн популяци, хамгийн олон тоогоор үлдсэн хулангийн популяци, зэрлэг тахийн хамгийн том популяцийн нэг, дэлхийн хэмжээнд чухал ач холбогдолтой Сибирийн янгир, хар сүүлт, цагаан зээр, мөн цоохор ирвэсийн тогтвортой популяцийн нутаг билээ. Мөн тус 6 тусгай хамгаалалттай газар нутагт үндэсний хэмжээнд ховордсон 30 гаруй төрлийн хөхтөн амьтад, хэвлээр явагчид, шувууд амьдардаг бөгөөд тэдгээрийн ихэнх нь эх газрын эрс тэс уур амьсгалд онцгойлон зохицсон байдаг.

Уг төслийг 2023 оны 6-р сард Монгол Улсын Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ), Сукков сангийн

төслийн менежмент (төслийн хуудасны холбоосыг доороос үзнэ үү) болон ОУТГ-ын (2025 оны 2-р сарын 2 хүртэл) удирдлага дор эхлүүлсэн.

Эдгээр экосистем дэх ашигт малтмалын нөөцийн эрэл хайгуулын ажил асар их дарамт шахалт учруулж байгаа тул Монголын говийн огт хөндөгдөөгүй ландшафтыг хамгаалах зорилго нь илүү чухал бөгөөд яаралтай юм. Хүдрийг Хятад руу тээвэрлэхэд хүнд даацын авто зам, төмөр зам хэрэгтэй.

Ийм эмзэг амьдрах орчныг эдгээр шугаман бүтцээр хэсэгчлэн хувааж саад үүсгэх нь хөдөлгөөн ихтэй байдаг тал хээрийн том амьтдад хүдэр олборлолтоос үүдэлтэй хог хаягдал, ялгаралтаас үүссэн бохирдолоос ч илүүгээр ноцтой хор хохирол учруулах болно. Ялангуяа их говийн дархан цаазат газрын урд хэсэгт хилийн боомт байгуулах тухай санал нь иргэдийн бухимдлыг төрүүлж байна. Нэгэнт боомт байгуулагдвал говийн хамгийн том, хамгийн алслагдсан, хамгийн онгон дархан цаазат газарт дэд бүтцийн бүтээн байгуулалт өрнөнө.

Маш ховордсон зэрлэг тэмээний (Camelus ferus) үлдсэн сүүлчийн популяци болон мазаалай хэмээх (Ursus arctos gobiensis) цөлд дасан зохицсон бор баавгайн дэлхийн цорын ганц популяци нь дэлхийн хамгийн том нөөц газар болох байгалийн үзэсгэлэнт Монголын Говийн их дархан цаазат газрын А хэсэгт амьдардаг.

Зураг: ©Петра Каценский

Төв Ази бол дэлхийн хамгийн чухал хүйтэн хээр буюу хагас цөлийн эх нутаг юм

Биосферийн нөөц газрын стратеги: уур амьсгалын өөрчлөлтийн үед

Эрс тэс уур амьсгалтай бүсүүд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сэрүүн бүсээс илүү эрчимтэй мэддэг. Алтайн цаст тал, Зүүнгарын говийн нүцгэн бэлчээр ч мөн адил. Тэндхийн хоньчид ган гачиг нэмэгдэж байна хэмээн ярьцгааж байна. Батгай өгөгдөл одоогоор бүрдээгүй байгаа (бид үүн дээр ажиллаж байна) боловч бид аажмаар нөмөрч буй өөрчлөлт нь усны цэгүүд болон хээрийн экосистемд хэрхэн нөлөөлж байгааг аль болох эрт үнэлэх хэрэгтэй. Улмаар тэр дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг өөрчлөх хэрэгтэй.

Усны цооног, бэлчээрийн ашиглалт шийдвэрлэх нөлөөтэй. Эдгээр нь зэрлэг туурайтан амьтад болон нүүдэлчдийн хувьд ялгаагүй чухал ач холбогдолтой юм.

Булаг шандыг нөөц болгон ашиглах, усан сангаас (тухайлбал Бижийн усан сан) ус татах нь урт хугацаанд тогтвортой хийгдэх ёстой. Нөөцийн ус судлалын (ялангуяа зэрлэг ан амьтад, нүүдэлчдийн хувьд нэн

шаардлагатай баян бүрдүүд) талаар сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгааг шинэ менежмент төлөвлөгөөний усны балансыг оновчтой болгох стратегид тусгана.

Тогтвортой байдлаас гадна анхаарууштай нэг зүйл бол Монголын малын тоо толгой асар их буюу мянганы эхнээс 215%-иар өссөн явдал юм! Энэ хугацаанд нөөцийг улирлын чанартайгаар ашигладаг 280 гаруй нүүдлийн малчдын ямаа, хонин сүрэг өссөн байна. Бэлчээрийг илүү эрчимтэй ашигласнаар ган гачигт нөлөөлж, улам хурцатгадаг. Дархан цаазат газарт чөлөөтэй бэлчиж буй гэрийн адууны тоо нэмэгдэж байгаа нь тусгай хамгаалалттай газар нутгийн зорилттой бүрэн нийцэхгүй байна. Тэд халуунд ховор зэрлэг тахь, хулантай ус, тэжээл булаацалдаж гүү хураахаар өрсөлдөж байна.

Үржил шимгүй бэлчээрийг хэт ашиглахгүй байх нь бэлчээрийн нүүдэлчдийн эрх ашигт ч нийцнэ. Гэхдээ заавал дагаж мөрдөх дүрэм шаардагдана - энэ талаар дэлгэрэнгүйг х. 6-аас харна уу. Нутаг бүрт нүүдэлчин малчид хоршоо байгуулж, бэлчээрийг ашиглах талаар харилцан тохиролцох нь зүйтэй болов уу. Зайлшгүй шаардлага: байгаль хамгаалагчид тусгай хамгаалалттай газар нутгийн дүрмийг дагаж мөрдөхөд хяналт тавьж, дагаж мөрдөхийг шаардах ёстой.



Монголын хүйтэн хээр нутаг дахь сэтгэл татам, эртний зэрлэг адууны оршин тогтнох эсэх нь тэдгээрийг нутагшуулсан шим мандлын нөөцийг зохистой, тогтвортой ашиглахаас хамаарна. Зургийг: © Фреди Цуи

Бэлчээрийг хэт их ашиглаж хомсдолд хүргэхгүй байх нь бэлчээрийн нүүдэлчдийн эрх ашигт ч нийцнэ.

Мал, ан амьтан, хүний эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

2023/2024 оны өвөл бидэнд цаг агаарын таамаглаж буй эрс тэс үзэгдлүүдэд хангалттай бэлтгэлтэй байвал тэдгээрийн нөлөөллийг бууруулах боломжтойг харууллаа. Тусгай хамгаалалттай газар нутагт өвчлөлийг хянах нь мөн адил чухал юм. Үүнийг 1998 онд пироплазмозын дэгдэлтийн дараа нэвтрүүлсэн бөгөөд дараа нь боом болон уушгины хатгалгааг эрт илрүүлэх боломжтой болсон. Харин сүүлийн 10 жилд тахийн үхлийн шалтгааны талаархи өгөгдөл бараг байхгүй.

Ийм мэдээлэл нь үхрийн халдварт олон өвчинд үхэр сүргээс гадна бэлчээр усны нөөцийг зэрэгцэн ашигладаг зэрлэг ан амьтан, малчид бүгд өртөх томоохон эрсдлийг арилгахад чухал ач холбогдолтой юм. Өвчин эмгэгийг эрт илрүүлэх, цаг тухайд нь хянахын тулд гэрийн болон зэрлэг амьтдын үхлийн шалтгааныг нарийн баримтжуулах, тодруулах шаардлагатай. Зөвхөн эрүүл мэндийн зөв хяналтыг хийснээр гамшгийн эрсдэлтэй өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх боломжтой.

Энэ нь тухайн талбайд үхсэн амьтдын (зэрлэг болон гэрийн) бичиг баримтыг нягт нямбай хөтлөх, дээж авах, зөв боловсруулах, хадгалах, хорогдол ихэсч байгаа эсэхийг тогтоож нэн даруй үйл ажиллагааны төлөвлөгөө гаргана гэсэн үг юм. Үүний тулд мал эмнэлгийн хүрээлэн, орон нутгийн малын эмчтэй сайтар холбоо тогтоох

шаардлагатай бөгөөд ингэснээр яаралтай тусламж үзүүлж, нэн даруй арга хэмжээ авах боломжтой болно.

Нөөц болон хамгаалалтын бүсэд байгаа малыг эрүүлжүүлэх нь зайлшгүй чухал. Ингэж байж л эрх баригчид тахь, хулан, зээрийг хамгийн чухал идээшсэн газар нь үр дүнтэй хамгаалж, тахь нутагшуулах хөтөлбөрийг амжилттай үргэлжлүүлэх боломжтой. Үүний тулд улстөрчид, яамд, малчдын ухамсарыг өөрчлөх шаардлагатай. Мөн санхүүжилт хүчин чадал чухал.

Бут сөөг цөлжилтөөс хамгаална

Стратегийн чухал ажил бол хар заг (Haloxylon ammodendron)-ийн үржүүлгийг хамгаалах, түлшинд хэт их ашигласан газрыг ойжуулах явдал юм. 8 метр хүртэл өндөр ургадаг энэхүү шүүслэг ишт бут сөөг нь ган, шорвог хөрсөнд тэсвэр сайтай. Эдгээр нь говийн нүүрстөрөгчийн хамгийн чухал агуулах төдийгүй зузаан холтостоо их хэмжээний ус хуримтлуулж, өргөн салаалсан үндэсний систем нь сул хөрсийг хамгаалдаг. Ийнхүү цөлжилтийн эсрэг байгалийн холбоотон болдог. Тэд мөн янз бүрийн амьтдын хоол хүнс, амьдрах орчин болж салхинаас хамгаалдаг.

Иймд 2015 оныг хүртэл нэлээд сийрэгжсэн (харин тэр цагаас хойш тогтвортой байгаа) заган ойг нөхөн сэргээх, өгөршихөөс хамгаалах нь менежментийн шинэ төлөвлөгөөний чухал зорилт юм.

"Танай бэлчээр одоо байгалийн нөөц газарт орсон!"

Та үүнийг хөмсөг зангидан уншсан байх. Харин 2019 онд ГИДЦГ-ын Б хэсгийн талбай хоёр дахин нэмэгдсэний улмаас хохирсон айлуудад яг ийм зүйл тохиолдсон.

Орон нутгийн оршин суугчдад газар ашиглалтын хязгаарлалт хийсний нөхөн төлбөрийг хэрхэн төлөх вэ? Урт хугацаанд нөөцөөс нэмэлт орлого бий болгосноор буюу тухайлбал, ноос ноолууранд нэмүү өртөг шингээх замаар. Энэ нь ямаанаас илүү орлого олно гэсэн үг. Ингэснээр зэрлэг ан амьтдын нөөц газарт бэлчээрийн өрсөлдөөнийг бууруулж, бэлчээр тахлагдах нь багасч, улмаар цөлжилт буурна. Эдгээр нь шим мандлын нөөц газарт нүүдэлчдийн соёл оршин тогтноход чухал ач холбогдолтой.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд бид ноолуурын үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн хөтөлбөрүүддээ хийх хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлж байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний хамгаалалтын бүсийн бэлчээрийн нүүдэлчидтэй байгуулсан гэрээ нь малын тоо толгой, бэлчээрийн ашиглалтыг зохицуулдаг. Харин малчид "Хөвчийн цагаан сорт" ноолуурын хоршоондоо 30 мянган ам.долларын баталгаа гаргуулж, ноосыг мэргэжлийн аргаар самнах, савлах, бэлчээрийг оновчтой зохион байгуулах сургалтанд хамрагджээ.

Тус хоршоо нь маш сайн чанарын ноолуур ноосоо зуучлагчдад бус эцсийн хэрэглэгчдэдээ шууд зардаг. Өнгөрсөн онд тус байгууллагын 74 гишүүн зээлээ төлж барагдуулснаар 2400 орчим ам.долларын цэвэр ашигтай ажиллажээ. Тэд мөн ноолуур боловсруулагчдаас 44 холбогдох хүсэлт хүлээн авсан ч тэдний заримд их хэмжээний ноос хэрэгтэй, зарим нь түүхий ноос биш зөвхөн утас худалдаж авдаг. Иймд хоршоо нь Монголд илүү их нэмүү өртөг бий болгох эсвэл тэмээний ноосны борлуулалтыг турших хэрэгтэй. Гэхдээ эхлэл амжилттай болж, сонирхол өндөр байна. Шаардлагатай зүйл бол хүчин чадлаа хадгалах явдал юм.

Энэ нь аялал жуулчлалын нэмэлт орлогод ч хамаатай. Өнгөрсөн жил олон улсын 31 аялагч тусгай хамгаалалттай газар нутгийг зорьж "насан туршийн аялал" (нэгэн урам зоригтой оролцогчийн хэлснээр) хийжээ. 19,000 гаруй ам.долларын цэвэр ашиг нь энэ бизнесийг зөв явуулж чадвал хөгжлийн асар их боломж байгааг харуулж байна. Орон нутгийн оршин суугчид үүнийг ашиглахын тулд шаардлагатай ур чадвар эзэмшиж, бүс нутгийн аялал жуулчлалын дэд бүтцийг урт хугацаанд хөгжүүлэх шаардлагатай. Монгол улс маш их зүйлийг санал болгож байна: гайхалтай байгалийн өв дундах гайхалтай соёл.



Photo: Rebekka Blumer

Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний хамгаалалтын бүсийн бэлчээрийн нүүдэлчидтэй байгуулсан гэрээ нь малын тоо толгой, бэлчээрийн ашиглалтыг зохицуулдаг.

Зүйлийн хөрөг: Палласын пика¹

Богино хөл, дугуй чихтэй, хад чулуунд дуртай энэ зүйл (*Ochotona pallasii*) нь туулайн бүлд хамаардаг.

Уулын бүсийн реликт буюу үлдэгдэл тогтоц газруудад тархсан 29 зүйл (Азид 27, Хойд Америкт 2) нь анатомийн хувьд нэг төрөл Пикагийн бүлгийг бүрдүүлнэ. 5 төрлийн амьдрах орчин бий: сайр чулуу, хад, хадархаг энгэрт ухсан нүх (тарвагатай төстэй), бут сөөг, гүвээ толгодод ухсан нүх. *Ochotona pallasii* нь нягтрал, газарзүйн байршлаас хамааран сайр чулуу болон чулуурхаг энгэр бэлийн дунд сэлгэн амьдардаг холимог төрөл юм.

Пика тарвагатай ижил (экологийн) үүр ухдаг. Ууланд цаг уурын нөхцөл ихэвчлэн эрс хатуу байдаг хэдий ч эдгээр бяцхан амьтад өвөл амардаггүй. Тэдний иддэг олон төрлийн нарийн өвс, ногоон ургамал өвлийн улиралд олдохгүй. Ихэнх пика 7-р сараас өвс нөөцөлж эхэлдэг. Тэд жил бүр шинэ ургамлыг овоолон цуглуулж, нэг газар хатаана. Палласын пика нь 14 кг хүртэл хэмжээгээр өвс хурааж нүхэндээ тусгай тасалгаанд хадгалдаг. Мөн туулайн төрлийн амьтан тул анхдагч боловсруулалтын ялгадсаа энд бас хадгална. Энэхүү ялгадас нь мухар олгойнд байх нянгаар урьдчилан боловсруулагдсан целлюлозыг агуулах ба гэдэснээс гарсан дор буюу эсвэл дараа нь хэрэглэнэ.

Энэ зүйл нь зүүн өмнөд Алтай, Монголын баруун болон өмнөд хэсэгт (мөн зүүн бүсийн зарим алслагдсан газар нутагт), ихэвчлэн 1000-аас 3200 метрийн өндөрт эгц хад, өвслөг энгэрт байх эзэмшил газартаа амьдардаг. 150-270 гр жинтэй, 16-23 см урттай, харьцангуй том биетэй. Тэд 100-аас 700 м² талбайтай (эрэгчингийнх нь хоёр дахин бага) нутаг дэвсгэрээ сайтар хамгаалж, шээс, ялгадас, пирамидуудаар тэмдэглэдэг. Бусад пика нар нүхнийхээ үүд хаалгыг чулуу, малын баасаар хийсэн жижиг цайз хэрмээр бэхэлдэг. Палласын пикагийн нүх нь 40 хүртэл хаалгатай байж болно.

Энэхүү олон эмэгчинт зүйлийн үржлийн улирал 3, 4-р сард эхэлдэг. Нийт 4-5 сар үргэлжилдэг бөгөөд энэ хугацаанд эмэгчин тус бүр 2-3 төрж 3-8 зулзага гаргадаг. Хээлтэй байх хугацаа 3-4 долоо хоног байна. Зулзагаа үүрэндээ бойжуулж, 2-3 долоо хоногийн турш хөхүүлдэг. Эм нь 4-6 долоо хоногийн дараа, эр нь хоёр дахь жилдээ бэлгийн бойжилд хүрдэг.



Пика нь төрөл зүйлээс хамааран нийгэмшсэн эсвэл маш нийтэч байдаг. Палласын пика нь нийтэч боловч эзэмшил газраа хамгаалахдаа дайчин. Тэд ихэвчлэн өдрийн цагаар идэвхтэй байх ба өвс тэжээл нөөцлөх болон орооны үедээ шөнийн эхний хагаст ч идэвхтэй байдаг. Тэд үд дундын халуун, салхинаас зайлсхийдэг боловч амарч, наранд шарах дуртай. Гэхдээ идэвхтэй цагийнхаа бараг тал хувийг харуулд зарцуулдаг. Аюулын дохиогоор тэд эзэмшил газартаа махчин амьтдаас сэрэмжлүүлэх бөгөөд дуудлагын давтамжаараа ялгаж зааж өгдөг. Харин зэрлэг шувуудаас тэд чимээгүйхэн нуугдана.

Зарим төрлийн пикас уртаар исгэрэн дуугарч эзэмшил газраа мэдэгдэнэ. Мөн хүзүүний булчирхайгаараа ялгаруулдаг үнэр болон хураасан шээс, ялгадсын үнэр нь харилцан холбогдоход үнэрт тэмдэглэгээ болж өгдөг.

Олон тооны махчин шувууд, махчин амьтдын олз идэш болохын хувьд пика нь уулын экосистемд чухал үүрэг гүйцэтгэдэг. Алтайн уулын эрлийз (*Mustela altaica*) пикаг агнахдаа мэргэшсэн. Төвдийн хар уруултай пика нь амьдрах орчныхоо ургамал, шувуудын биологийн олон янз байдлыг нэмэгдүүлдэг болохыг тогтоосон. Тэдний нүх хөрсийг агааржуулж, газарт үүрлэх шувуудын хоргодох байр болдог. Гэсэн хэдий ч малын бэлчээрийг сүйтгэдэг гэх шалтгаанаар тэднийг хархны хороор их хэмжээгээр устгаж байна.

Шууд устгалаас гадна ойн хомсдол, уур амьсгалын өөрчлөлт (дэлхийн дулаарал) пикад заналхийлж байна. Ихэнх зүйлүүд нь (үүнд *O. pallasii*) ховордсонд тооцогддоггүй. Гэхдээ тэдний экологийн талаархи бидний мэдлэг хязгаарлагдмал бөгөөд тусгаарлагдсан популяци амархан дарамтанд ордог билээ.

¹ Lissovsky AA (2016). Family Ochotonidae (Pikas). Pp28-60 in: Wilson DE, Lacher TE, Mittermeier RA eds. (2016): Handbook of the mammals of the world. Vol 6., Lagomorphs and Rodents I. Lynx Edicions, Barcelona

Зэрлэг адууны ирээдүйг хамтдаа бататгая



“Монголын говийн байгалийн үнэт өв, эртний өв соёлоо хойч үедээ өвлүүлэн үлдээх үйлсэд хувь нэмрээ оруулж байгаа нь миний ажил үйлсэд их урам өгч байна”.

Насантогтохын Анхзаяа, ОУТГ Монгол, Улаанбаатар, Эрдэм шинжилгээний ажилтан

ОУТГ нь нэр хүндтэй ажил эрхэлдэг.

Хандив бүр зэрлэг адуу, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад шууд зориулагдана.

Таны хандив бидэнд ингэж тусалдаг - Танд маш их баярлалаа!

150,000 ТӨГРӨГ

Биж тосгоны сургуулийн сурагчдад зориулсан хандив

250,000 ТӨГРӨГ

Байгаль хамгаалагчийн Тахийн мониторингийн өдрийн аялалыг санхүүжүүлнэ

300,000 ТӨГРӨГ

Та бүхний хувь нэмрээр нөөц газарт 1000 м2 талбайд ус хуримтлуулагч заган бутыг сэргээн ойжуулах боломжтой.

600,000 ТӨГРӨГ

Та орон нутгийн 20 малчдыг бэлчээрийн менежмент болон ноолуурын хоршооны менежментийн чиглэлээр 1 сар сургана.



Наадмаар буддын шашны ном хурж буй нь, 2018 он
Зургийг: © Кирил Руосо

Таны ямар ч хэмжээний хандив Төв Азийн тал нутгийн зэрлэг адуу, үлдсэн ургамал, амьтан, нүүдэлчдийн соёлыг хадгалахад тустай.

Facebook Instagram-аар биднийг дагаарай



Тахийн унага үрчлээрэй! 300,000 төгрөг

Та “Тахийн найз нөхөд” болох уу?

- Хувь хүний гишүүнчлэлийн жилийн хураамж **130,000 төгрөг**
- Оюутан, залууст зориулсан “Унага” гишүүний хураамж **50,000 төгрөг**

Хандивын данс

Олон Улсын Тахь Группын Монгол дахь төлөөлөгчийн газар
ХХБ 499114883 ам. долл.
499248691 төгрөг



Эрхлэн гаргасан
Freunde des Wildpferdes
c/o Stiftung Wildnispark Zürich
Alte Sihlstrasse 38
CH-8135 Sihlwald / ZH
www.savethewildhorse.org
info@savethewildhorse.org
itg.ulaanbaatar@gmail.com

Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв. FSC
(Ойн Удирдах Зөвлөл)/ EХ Эко шошгоны цаас

